



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№211 /420/

2022.11.23

Тусгай дугаар

МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АЖИЛТНЫ ӨДӨР, ЦЭРГИЙН ЭРДЭМТДИЙГ МОНГОЛ УЛСАД БЭЛТГЭЖ ЭХЭЛСНИЙ 30 ЖИЛ, АХИСАН ТҮВШНИЙ СУРГАЛТЫН АЛБАНЫ 30 ЖИЛИЙН ОЙН БАЯРЫН МЭНДИЙГ ӨРГӨН ДЭВШҮҮЛЬЕ!

МЭНДЧИЛТЭЭ



Эрхэм хүндэт эрдэмтэн багш, судлаачид аа!
"Монгол Улсад цэргийн эрдэмтэд бэлтгэж эхэлсний 30 жилийн ойн баяр"-ыг тохиолдуулан ҮБХИС-ийн үе үеийн эрдмийн хамт олон, Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчин, Төрийн цэргийн байгууллага, төрийн алба, хувийн хэвшилд ажиллаж байгаа доктор, профессор болон ахмад эрдэмтэд та бүхэндээ чин сэтгэлийн халуун мэндчилгээ дэвшүүлье.

Өнөөгөөс 30 жилийн тэртээ 1992 оны 11 дүгээр сард Цэргийн их сургуулийн дэргэд, Монгол Улсад цэргийн эрдэмтдийг бэлтгэхээр "Эрдэм шинжилгээ, адъюнктурын тасаг" байгуулж, 4 офицер өдрөөр, 2 офицер эчнээгээр элсэж тусгай хөтөлбөрөөр сургалт явуулж эхэлсэн нь Монгол Улсад цэргийн эрдэмтэд бэлтгэх их үйлсийн гараа болсон билээ.

Тэр үед Батлан хамгаалах салбарын хэмжээнд цөөн хэдхэн "дэд эрдэмтэн" зэрэгтэй офицер байсан нь бүгд гадаадад суралцаж диссертациаа туурвисан хүмүүс байсан.

Тэгвэл өнөөдөр цэргийн эрдэмтдийг Монгол Улсад бэлтгэж ирсэн 30 жилийн хугацаанд ҮБХИС-ийн дэргэдэх "Эрдмийн зэрэг хамгаалуулах зөвлөл"-д 123 судлаач эрдмийн зэргээ хамгаалж, Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчин болон ОБЕГ, цагдаа, тагнуул, шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба гэх зэрэг хүчний байгууллагад, мэргэжлийн дагуу үр бүтээлтэй ажиллаж байна.

Цэргийн эрдэмтдийн хийсэн суурь болон хавсарга судалгаа, эрдэм шинжилгээний ажлын чанар нь өнөөгийн тавигдаж буй шаардлагыг хангаж байгаа бөгөөд судалгааны ажлын үр дүн, зөвлөмж амьдралд хэрэгжиж, Монголын Улсын Зэвсэгт хүчний бэлэн байдал, байлдааны чадавхыг дээшлүүлэх, үндэсний аюулгүй байдлыг хангах үйл хэрэгт бодит хувь нэмэр оруулж байна.

Монгол Улсын хэмжээнд болон Батлан хамгаалахын сайдын нэрэмжит шилдэг бүтээлийн шалгаруулалтад манай сургуулийн эрдэмтэн судлаачид, багш, оюутнууд идэвхийлэн оролцож тэргүүн байруудад шалгарч ирсэн нь бидний бахархал билээ.

Монголын үе үеийн эрдэмтэн судлаачид, сургуулийн эрдмийн хамт олондоо Монгол Улсад цэргийн эрдэмтэд бэлтгэж эхэлсний 30 жилийн ойн баярын мэндийг хүргэж, эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн өрөөе.

Та бүхнийг төрийн босоо цагаан сүлд нь ивээж, эрдэм номын цагаан буян дэлгэрэх болтугай.

**ҮБХИС-ИЙН ЗАХИРАЛ, ПРОФЕССОР
БРИГАДЫН ГЕНЕРАЛ П.ЖАРГАЛАН**

АХИСАН ТҮВШНИЙ СУРГАЛТЫН АЛБА НЬ 2022-2023 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД...



➢Эрдмийн сургууль байгуулах, сургалтыг танхим болон цахим хэлбэрээр хослуулах

➢Суралцагчдын, эрдэм шинжилгээ, судалгааны ажил явуулах, шинжлэх ухааны онол арга зүйн мэдлэгийг "бүтээгдэхүүн" болгох чадварыг нэмэгдүүлэх

➢Олон улсын түвшинд, хянан магадалгаа хийгддэг сэтгүүлд эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлсэн тохиолдолд, судалгааны ажлын кредит тооцох, төлбөрийн тодорхой хувьд хөнгөлөлт үзүүлэх

➢ҮБХИС-ийг хөгжүүлэхэд бодит ач холбогдлоо өгч байгаа судалгааны ажлыг сургуулийн захирлын нэрэмжит тэтгэлэгт хамруулах

➢Профессор багш нар, докторант, магистрантуудыг мэргэжлийн чиглэлээр судалгааны төсөл, хөтөлбөрт татан оролцуулж, эрдэм шинжилгээ, судалгааны ажилд нь дэмжлэг үзүүлэх

➢Ахисан түвшний сургалтын албаны үйл ажиллагааг өргөтгөж, сургууль болгох, докторант, магистрантын сургалтын хөтөлбөрийг төгөлдөржүүлэх, нийт судлаачдын эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнг дээшлүүлэх дээрх зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

Д.Ганхуяг: МАНАЙ ЭРДЭМТДИЙН БҮТЭЭЛҮҮД ОЛОН УЛСАД ТЭРГҮҮЛЭХ ТҮВШИНД ХҮРСЭН

Ахисан түвшний сургалтын алба үүсэн байгуулагдаж, цэргийн эрдэмтдийг Монгол Улс дотооддоо бэлтгэж эхэлсний 30 жилийн ойд зориулсан баярын хурлын үйл ажиллагаа ЦДБЭЧ-ын их танхимд ёслол төгөлдөр болж байна.

Эл хуралд ҮБХИС-ийн үе үеийн эрдмийн хамт олон, Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчин, Төрийн цэргийн болон хууль сахиулан байгууллага, төрийн алба, хувийн хэвшилд ажиллаж байгаа доктор, профессор болон ахмад эрдэмтэд хүрэлцэн иржээ.

Энэ үеэр БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга бригадын генерал Д.Ганхуяг хэлсэн үгэндээ эрдэм шинжилгээний ажлыг амжилттай явуулах гол хүчин зүйл болсон цэргийн эрдэмтдийг 1990-ээд оноос хойших 30 жилийн хугацаанд дотооддоо бэлтгэх болсон нь Батлан хамгаалах салбарт цэргийн шинжлэх ухааныг хөгжүүлэх, боловсон хүчнийг сургаж бэлтгэхэд гарсан томоохон ахиц дэвшил болсныг онцлов. Түүнчлэн эдүгээ цэргийн шинжлэх ухаан тэр дундаа аюулгүй байдал, цэргийн түүх, зэвсэг, техник, инновацийн зарим чиглэлээр манай эрдэмтдийн судалгаа хөгжүүлэлтийн ажил дотоодод төдийгүй олон улсын хэмжээнд тэргүүлэн өрсөлдөхүйц түвшинд хүрч улс орныхоо нийгэм, эдийн засгийн хөгжилд үнэтэй хувь нэмрээ оруулсаар буйд чин сэтгэлээсээ талархаж явдгаа илэрхийллээ.

Үргэлжлүүлэн хүрэлцэн ирсэн зочид, төлөөлөгчдөд 2022 оны Батлан хамгаалахын сайдын нэрэмжит Шинжлэх ухаан, технологийн шилдэг бүтээлийг танилцуулсан бөгөөд идэвх зүтгэл, боловсролын салбарт оруулсан хувь нэмрээрээ манлайлсан зарим эрдэм шинжилгээний тэргүүний төв, эрдэм шинжилгээний ажилтнуудыг салбарын шагналаар шагнаж урамшуулсан юм.

Ахисан түвшний сургалтын алба нь үүсгэн байгуулагдсан цагаасаа өнөөг хүртэлх хугацаанд 8 удаа бүтцийн өөрчлөлтөд орж байсан боловч үндсэн үүргээ цалгардуулалгүй биелүүлэн ажилласаар иржээ. Тухайлбал Ахисан түвшний сургалтын алба нь өнөөдрийн байдлаар "Цэргийн шинжлэх ухаан", "Батлан хамгаалах судлал", "Аюулгүй байдал судлал" гэсэн гурван чиглэлээр докторын, "Цэргийн шинжлэх ухаан", "Батлан хамгаалах судлал", "Кибер аюулгүй байдлын цэргийн сургалт", "Хуурай замын цэргийн сургалт", "Агаарын цэргийн сургалт", "Аюулгүй байдал судлал", "Төрийн удирдлага" гэсэн долоон чиглэлээр магистрын түвшинд боловсрол сургалтын үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 2022-2023 оны хичээлийн жилд гэхэд 570 гаруй магистрант, докторантуудыг ахисан түвшний сургалтад хамруулан сурган бэлтгэж байгаа аж.

Ө.НАСАНТОГХОХ



НОМЫН ЦАГААН БУЯН ИВЭЭЖ БАЙХЫН ЕРӨӨЛИЙГ ӨРГӨН ДЭВШҮҮЛЬЕ

ҮАБЗ-ийн ахлах референт, доктор, профессор, хурандаа Л.БОЛДБААТАР:

-Миний бие 2001 онд ҮБХИС-ийн докторантурын өдрийн ангид элсэн суралцсан цагаасаа сургуулийнхаа Ахисан түвшний сургалтын албатай холбогдож, эрдмийн их далайд шумбан орсон билээ. Тухайн үед сургуульд мөрдөж байсан журмын дагуу өдрийн докторантуудад ямар нэгэн ажил давхар хариуцуулж байсан жишгээр миний бие эхлээд бакалавр, дараа нь магистр, эцэст нь докторын сургалт хариуцсан арга зүйч багшаар нийтдээ 10 гаруй жил ажилласан байна.



нэмрээ оруулж, цэргийн ухаанаар докторын зэргээ амжилттай хамгаалсан, олон эрдэмтний урьдчилсан болон жинхэнэ хамгаалалтыг зохион байгуулалцаж явсандаа үргэлж бахархаж явдаг юм.

Тухайн үед надтай мөр зэрэгцэн ажиллаж байсан эрхэм хүмүүс болох албаны дарга доктор, профессор С.Уламбадрах, магистрын сургалт хариуцсан арга зүйч багш доктор, дэд профессор Б.Хандсүрэн, хурандаа С.Төмөрхуяг, эрдэм шинжилгээний ажилтан Ч.Мөнхжаргал, Л.Маналжав, Р.Мөнхцэцэг нараа эргэн дурсахад таатай байна.

Миний бие БХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар БХИС-ийн докторантур, магистрантурын сургалт, эрдэм шинжилгээний албанд докторын сургалт хариуцсан арга зүйч багшаар

томилогдон ажиллах хугацаандаа магистр, докторын стандартыг боловсруулж батлуулах, докторантурын хорооны болон докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн ажиллах журам, бусад холбогдох баримт бичгүүдийг боловсруулахад хувь

Цэргийн эрдэмтдийг Монгол Улсад бэлтгэж эхэлсний 30 жилийн ойг тохиолдуулан ҮБХИС-ийн Ахисан түвшний сургалтын албаны хамт олондоо ажлын өндөр амжилт хүсэж, номын цагаан буян үргэлж ивээж байхын өлзийтэй ерөөлийг өргөн дэвшүүлье.

ЭРДМИЙН ЗЭРГИЙН СУРГАЛТ БОЛ НӨР ИХ ХҮЧ ХӨДӨЛМӨР, ХИЧЭЭЛ ЗҮТГЭЛ ЮМ

БХЭШХ-гийн эрдэмтэн, нарийн бичгийн дарга, доктор, профессор, хурандаа Ц.ДЭМЧИГСҮРЭН:
-Миний бие ОХУ-д

ОХУ-ын Цэргийн их, дээд сургууль, академийн эрдмийн зэргийн сургалтын хөтөлбөрүүдийг судалж, танилцсаны дээр ЦИС-ийн сургалт, эрдэм шинжилгээний

цагаас хойш Зэвсэгт хүчний анги, байгууллагаас эрдэм шинжилгээ, судалгааны ажил туурвих сонирхолтой залуучууд жил ирэх бүр өсөн нэмэгдэхийн хэрээр эрдмийн зэргийн сургалтын эрэлт, хэрэгцээ шаардлага улам бүр ихсэж сургалтын албаны хөгжлийн өнөөгийн дүр төрхийг тодорхойлсон байна. Эрдмийн зэргийн сургалт бол нөр их хүч хөдөлмөр, хичээл зүтгэл, тэвчээр, цаг хугацаа, төсөв хөрөнгө шаарддаг, олон хүний уйгагүй оролцоотой явагдах ажил байдаг учир энэ албанд ажиллаж байсан, ажиллаж байгаа офицерууд, ажилтан албан хаагчдын талаар зөвхөн сайнаар л дурсах нь зүйн хэрэг.



академи төгсөж ирээд үүсэн байгуулагдаад удаагүй байсан ЦИС-ийн эрдэм шинжилгээ адьюнктурын тасагт эрдэм шинжилгээний ажилтнаар томилогдоход тасгийн даргаар дэд хурандаа Д.Мархаахүү, эрдэм шинжилгээний ажилтан дэд хурандаа Л.Чойбалсан, сургалт хариуцсан эрдэм шинжилгээний ажилтан бэлтгэл хурандаа Ж.Дашцэвэг нар ажиллаж байв. Бид тухайн үеийн

ажлын хүрээнд эрдмийн зэргийн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан батлуулж анхныхаа элсэгчдийг сонгон шалгаруулж авч байлаа.

Тухайн үеийн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, судалгааны график зэрэг зохион байгуулалтын оновчтой хувилбарын дагуу докторантууд ажиллаж эрдмийн зэргээ цаг хугацаандаа амжилттай хамгаалж байсныг эргэн дурсахад бахдалтай байна. Тэр

ҮБХИС-ийн Ахисан түвшний сургалтын албаны түүхэн замнал, мянга мянган доктор, магиструудын сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажлууд, ном бүтээлийн талаар ярьж дурсвал барагдахгүй их түүх, дурсамж болох тул өөрийн товч сэтгэгдлээ үүгээр өндөрлөө. Энэхүү гайхалтай сайхан үйл хэргийн талаар дараа дараагийн удаа дахин хөөрөлдөн дурсах ерөөл дэвшүүлэн ҮБХИС-ийн Ахисан түвшний сургалтын албаар овоглогдсон үе үеийн эрдэмтэн багш нартаа ойн баярын мэнд хүргэж эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

ЭРДЭМТЭН БОЛОХ АМАРХАН АЖИЛ БИШ

АТСА-ны докторын хөтөлбөр, сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн доктор, дэд профессор, дэд хурандаа Б.ХАНДСҮРЭН

-Миний бие докторын сургалт хариуцсан мэргэжилтнээр ажиллах хугацаандаа Цэргийн шинжлэх ухааны докторантурын хороо, Аюулгүй байдлын албаны докторын зэрэг хамгаалуулах зөвлөл, Батлан хамгаалах, аюулгүй байдлын докторын ажил хамгаалуулах зөвлөлөөр нийт 50 орчим докторантур амжилттай хамгаалахад нь тодорхой хувь нэмрээ оруулсан гэж боддог.

л хүч хөдөлмөр, цаг хугацаа ордог. Эрдэмтэн болсон хүн л энэ бүхнийг ойлгоно гэж боддог.

Би БХИС-ийн эрдмийн хамт олон, тэр дундаа ДМСЭША-ны хамт олонтой 10 гаруй жил хамтран ажиллаж эрдэмтэн бэлтгэх үйлсэд хувь нэмрээ оруулж явсандаа баяртай байдаг.

Манай хамт олон аливаа ажлыг хийх аргыг нь олдог, холч хараатай, ноён нуруутай, нийтэч, хүнд тусархуу, сайхан сэтгэлтэй хүмүүс байж билээ. Тухайлбал хурандаа С.Уламбадрах, Л.Болдбаатар нарын хувьд ажилдаа няхуур, ажлыг хурдан, шуурхай сэтгэлээсээ хийдэг даруу төлөв зантай, Ч.Мөнхжаргал ажлыг сайн төлөвлөж, зохион байгуулдаг, Г.Батсүх ажлаас хойш суудаггүй, багаар ажиллах чадвартай, хүнд тусархуу, сайхан сэтгэлтэй гээд л хамт ажиллаж байсан хүмүүс минь бүгд ажилсаг, дайчин, чадварлаг хүмүүс. Ингээд л яриад байвал дундаршгүй их дурсамж, дуусашгүй их



жаргал энэ газарт бий. Тиймээс олон зүйлийг эс нурушин үе, үеийн эрдэмтэн багш нар, Докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн дарга, гишүүд, ЭШДМСА-ны хамт олон, удахгүй эрдэмтэн болох докторантууд, шавь нартаа батлан хамгаалах салбар дотооддоо цэргийн эрдэмтэн бэлтгэж эхэлсний 30 жилийн ойн баярын мэндийг хүргэе.

Эрдэм, номын цагаан буян өнөд дэлгэрч байх болтугай.

Түүхийн шаргал хуудаснаас...



Монгол Улс 1990 он хүртэлх хугацаанд цэргийн эрдэмтдийг, улсын хэмжээнд явуулдаг уралдаант шалгалтад оролцсон дүнг нь харгалзан элсүүлж ОХУ-ын (ЗХУ-ын хуучин нэрээр) цэргийн академи, дээд сургуульд илгээн сургаж бэлтгэдэг байв.

1991 оноос эхлээд, эрдмийн зэрэг эзэмших гэж буй офицерыг ЗХУ-д явуулахаа больсон. Учир нь: манай БХЯ-наас цэргийн эрдэмтдийг эх орондоо бэлтгэх бодлого баримталж эх олон улсын холбоотойгоор, юуны сургууль, БНХАУ-ын өмнө Батлан хамгаалахын цэргийн их, дээд сургуульд "Шинжлэх ухаан техникийн томилолтоор явуулж,

туршлага судлуулсны дараа тайлан саналыг нь сонсож, хэлэлцсэний үндсэн дээр Батлан хамгаалахын сайд дэслэгч генерал Ш.Жадамбаагийн н/19 тоот тушаал, 1992 оны 6 дугаар сарын 6-нд батлагдсан байдаг. Ингэж, ЦИС-ийн бүтцэд анх удаа "Эрдэм шинжилгээ, адьюнктурын тасаг" байгуулагдсанаар өнөөгийн "Ахисан түвшний сургалтын алба"-ны суурь тавигдсан түүхтэй.

Адьюнктур буюу цэргийн аспирантурт суралцах хугацаа 3 жил бөгөөд нийт 4960 цагийн хөтөлбөрөөр хичээллэнэ. Үүнээс 23 хувийг судалгаа



шинжилгээний ажилд, 77 хувийг мэргэшүүлэх хичээлд зориулдаг байсан.

БИ ЭРДЭМТЭН БАГШ НАРЫНХАА ЭРДМИЙН ШИМЭЭС ХҮРТЭСЭН АЗТАЙ ХҮН

Нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабын тоо бүртгэлийн офицер, магистрант, дэд хурандаа С.БАЯРМАГНАЙ:

-Ахисан түвшний сургалтын алба нь улс орны тогтвортой хөгжил, батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангахад шаардлагатай хүний нөөцийг бүрдүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулж байгаад магистрант, докторантууд бид бахархалтай байдаг.



ухаанаар магистрын боловсрол олгох сургалтад элсэн суралцаж буйдаа би туйлын сэтгэл хангалуун байна. Миний бие хувь зохиолоор ҮБХИС-тайгаа эрдмийн жимээр холбогдож 2010 онд бакалаврын боловсрол эзэмшин эрдэмтэн багш нарынхаа эрдмийн шимээс хүртсэн азтай хүн. Энэ ташрамд үе үеийн эрдэмтэн багш, судлаачдадаа нийт магистрантуудынхаа нэрийн өмнөөс болон хувиасаа баярын мэнд хүргэж аз жаргал эрдэм номын ариун үйлс нь эхэлсний 30 жилийн ойн босгон дээр цэргийн дэлгэрч байх ерөөлийг өргөн дэвшүүлье.

Дарга, ерөнхий редактор, хурандаа САНЖМЯТАВЫН ТӨМӨРХУЯГ

ЦАХИМ ХАЯГ
Батлан хамгаалах яам
Зэвсэгт хүчний Жанжин штаб

ЦАХИМ ХУУДАС
"Соёмбо" сонин
"Дуулга" студи

* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.
* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.
* Тус сонины мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс: 10018
Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn
Утас: 70001029, 3412 (дотуур)